

**СХНЭ -Н ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭД, БАЙГУУЛЛАГААС
ИРСЭН САНАЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ, ТЭДНИЙ
ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЙЛАН**

2025.05.14

УЛААНБААТАР ХОТ

2025 оны эхний хагас жил (05 сарын 13-ны) байдлаар ЭМТҮЧАБА-д иргэдээс нийт 33 өргөдөл, гомдол ирүүлсэн байна. Үүнд: 1111 төвөөс 14 , утсаар 2, амаар-3, бичгээр-14.

Өргөдөл гомдлын агуулга:

Д/д	Агуулга	2025 / эхний хагас жил /	
		тоо	хувь
1	Эм эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой	1	3.3%
2	Тусламж үйлчилгээтэй холбоотой	15	45.4%
3	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүй харилцаа, хандлагын зөрчилтэй холбоотой	14	42.4%
4	Автомашины зогсоолын үйл ажиллагаатай холбоотой	2	6%
5	Бусад	1	3.3%
	Дүн	33	100%

- ✓ СХД-н нэгдсэн эмнэлэгт ЭМД-н санхүүжилт, эм ханган нийлүүлэх компанийн нийлүүлэлттэй холбоотойгоор зарим эм тарианы тасалдал үүссэн, тухайн иргэн антибиотик мэдрэг чанарын шинжилгээнд 2 антибиотик мэдрэг гарсаны 1-ийг нь буюу Меропеним хийлгэх хүсэлтэй тул өөрөө эмнэлэгт хэвтэхээс татгалзсан.
- ✓ Тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлууд нь: Тасгуудын дотоод зохион байгуулалттай холбоотой 5, эмнэлзүйн үр дүнтэй харилцаа үүсгэж чадаагүйн улмаас тусламж үйлчилгээ аваагүй -10.

- ✓ Эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүй харилцаа хандлагын зөрчилтэй холбоотой - 14 гомдол ирсэн байна.
- ✓ Автомашины зогсоолтой холбоотой гомдол -2 байна.

Шийдвэрлэлт-100%

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

1. СХД-н нэгдсэн эмнэлэгт ЭМД-н санхүүжилт эм ханган нийлүүлэх компанийн нийлүүлэлттэй холбоотойгоор зарим эм тарианы тасалдал үүссэн ба эмийн хангалтаас хамааран 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хэвтүүлэн эмчлүүлэхээр шийдвэрлэн иргэнд мэдээлсэн.
2. Мэс заслын тасаг, Гэмтэлийн тасаг, Хоол үйлдвэрлэлийн тасгуудад хагалгаанд орсон өвчтөнгүүдэд нойл шөл өгөх талаар албан бичиг хүргүүлэн Мэс заслын тасаг, Гэмтэл согог мэс заслын тасгуудад хагалгаанд орсон өвчтөнд өгөх нойл шөлийг тасагт байршуулав.
3. Эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй харилцаа хандлагатай холбоотой гомдол нь 2025 онд 14 гомдол бүртгэгдсэн харилцаа хандлагын доголдол гаргасан ажилчдад цаашид ажил үүргээ гүйцэтгэхдээ ёс зүйтэй ажиллахыг анхааруулав. Ёс зүйн харилцаа доголдол гаргасан ажилчид нэг хүн дээр дахин давтагдсан тохиолдол байхгүй учраас тухайн ажилтанд сануулах анхааруулах арга хэмжээг авсан.
4. Ёс зүй харилцаа хандлагатай холбоотой гомдлын агуулга нь эмч, эмнэлгийн ажилчид болон үйлчлүүлэгч ялгаагүй харилцаа хандлага ёс зүйн асуудалтай байсан. Эмч, эмнэлгийн ажилчдын харилцаа хандлагын талаар сайжруулах ажлын хүрээнд ёс зүйн сургалтыг тогтмол явуулж байна.
5. Автомашины зогсоолын үйл ажиллагаатай холбоотой гомдол 2 удаа бүртгэгдсэн Хяналтын камер нь хөлдөж гацаад сэлбэгийг нь захисан байгаа. Удахгүй янзлахаар төлөвлөсөн. Ачаалал ихтэй үед хаалтыг бүрэн нээж зохицуулалт хийж байгаа. Цаашид анхаарч ажиллахыг анхааруулав.

Дүгнэлт:

2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 33 өргөдөл гомдол ирсэний дийлэнх хувийг тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол 45.4%-г эзлэж байна. Мөн ёс зүйн харьцаа хандлага зөрчилтэй холбоотой 42.4%-г эзэлж байгаад анхаарал хандуулж СХНЭ-н ёс зүйн хэсгийн хороотой хамтарч байгууллагын нийт ажилчдад ёс зүйн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Өргөдөл гомдлыг 100% шийдвэрлэж ажилласан.

ХЯНАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ
ЭРСДЭЛИЙН МЕНЕЖЕР: *Д. Намуун* Д.НАМУУН

ТАЙЛАН БИЧСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Г. Буяндэлгэр* Г.БУЯНДЭЛГЭР